

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 23-ны өдөр

Дугаар 01.18

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын
дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйл, “Монноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.18 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 244379 санал буюу ердийн олонхийн 100%-ийн саналаар Компанийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайланг, 244739 санал буюу ердийн олонхийн 100%-ийн саналаар Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг тус тус баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ТУЗ-д ажлаа дүгнүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д үүрэг болгосугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



С.Тунгалагтуяа

Б.Цолмон

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 23-ны өдөр

Дугаар 02.18

Улаанбаатар хот

Компанийн удирдлагыг сонгож
батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дугаар заалт, “Монноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.18 тоот тогтоол, ХЭХ-ын 01/18 тоот тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 5 санал буюу кумулятив 100%-ийн саналаар Адам Холдсвортыг, 5 санал буюу кумулятив 100%-ийн саналаар С.Мөнхжаргалыг, 5 санал буюу кумулятив 100%-ийн саналаар Х.Эрдэнэбаярыг, 5 санал буюу кумулятив 100%-ийн саналаар С.Алимааг, 5 санал буюу кумулятив 100%-ийн саналаар Ц.Цэнгэлбаярыг, 5 санал буюу кумулятив 100%-ийн саналаар П.Оюунбаярыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн энгийн гишүүнээр сонгосныг баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 5 санал буюу кумулятив 100%-ийн саналаар Х.Оюунгэрэлийг, 5 санал буюу кумулятив 100%-ийн саналаар И.Сэр-Одыг, 5 санал буюу кумулятив 100%-ийн саналаар Л.Бүрэнтэгшийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосныг баталсугай.
3. “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагааг удирдлага хяналтаар хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга /Адам Холдсворт/-д зөвшөөрсүгэй.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



С.Тунгалагтуяа

Б.Цолмон

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 23-ны өдөр

Дугаар 03.18

Улаанбаатар хот

Компанийн удирдлагын зардлыг
батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 63.1.13 дугаар зүйл, хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.18 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын 01.18 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 3 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн удирдлагын зардлын төсвийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 244379 санал буюу ердийн олонхийн 100%-ийн саналаар 125,448,700төгрөг /Нэг зуун хорин таван сая дөрвөн зуун дөчин найман мянга долоон зуун төгрөг/-өөр хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төсөвт багтаан компанийн удирдлагын зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Эрдэнэбаяр/-д, зардлын зөрцуулалтын үнэн зөв байдалд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Адам Холдворд/-д тус тус даалгасугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



С.Тунгалагтуяа

Б.Цолмон